



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 1327

Алтай хот

Газар эзэмших эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу газар эзэмших хүсэлт ирүүлсэн иргэн Ж.Болорчимэгийн эзэмших газрын хэмжээ, байршлыг 1-2 дугаар хавсралтаар баталж, эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн Ж.Болорчимэгтэй газар эзэмших эрхийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгож улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР